

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2025/117/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Зуунмод 2025 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Ахлах аудитор Ц.Саранчимэг

Утас: 70274302 Цахим хаяг: saranchimeg.ts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	12

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2025. 02.25 № 01/2025
танай _____-ны № _____-т

ТӨВ АЙМГИЙН ДЭЛГЭРХААН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА А.ЦЭДЭН-ИШ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Дуутын хадны бичээсний 400 жилийн ойг тэмдэглэхээр Сумын ИТХ-ын 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 02 тоот тогтоолоор 2024 оны 07 дугаар сарын 27,28-нд ойн арга хэмжээг зохион байгуулахаар шийдвэрлэж, тус арга хэмжээнд 25,000.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Төв аймгийн Дэлгэрхаан сумын ЗДТГ нь оны эхэнд 935,262.2 мянган төгрөгийн өр төлбөрөөс шинээр баригдсан ЗДТГ-ын барилгын ажлын төлбөрийн өглөгийг аймаг, сумын ОНХС-ийн эх үүсвэрээр 800,022.9 мянган төгрөг, бусад өглөг 64,000.0 мянган төгрөгийг тайлант онд төлж барагдуулсан байна.

Аудитын гол асуудал

Дэлгэрхаан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн "Сумын 2024 оны төсвийг тодотгон батлах тухай" 02 дугаар тогтоолоор төсвийг 95,075.1 мянган төгрөгөөр нэмж тодотгон зардлын дээд хэмжээг 966,419.0 мянган төгрөгөөр баталсныг 929,505.0 мянган төгрөг буюу 96,2 хувийг санхүүжүүлсэн байна.

412502284

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Дэлгэрхаан сумын Засаг даргын Тамгын газар нь гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 25 зорилт, 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжүүлж, гүйцэтгэлээр 92,0 хувийн биелэлттэй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	80,093,516.4	74,758,116.4
33	АВЛАГА	7,000,000.0	0.0
335	Бусад авлага	7,000,000.0	0.0
3351	Байгууллагаас авах авлага	7,000,000.0	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	73,093,516.4	74,758,116.4
354	Хангамжийн материал	54,093,516.4	56,508,116.4
35410	Бичиг хэргийн материал	31,300.0	178,000.0
35420	Аж ахуйн материал	7,574,816.4	6,050,216.4
35430	Сэлбэг хэрэгсэл	0.0	600,000.0
35440	Түлш, шатах тослох материал	250,000.0	0.0
35470	Бусад хангамжийн материал	46,237,400.0	49,679,900.0
35600	Мал амьтад	19,000,000.0	18,250,000.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,245,807,853.1	3,209,075,767.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,245,807,853.1	3,209,075,767.0
392	Биет хөрөнгө	3,201,956,999.0	3,068,308,369.5
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,560,284,096.1	2,560,284,096.1
39202	Хуримтлагдсан элэгдэл	-317,608,381.5	-377,584,677.7
39203	Авто-тээврийн хэрэгсэл	400,904,551.0	400,904,551.0
39204	Хуримтлагдсан элэгдэл	-208,671,474.4	-256,367,194.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	137,296,707.3	149,638,907.3
39206	Хуримтлагдсан элэгдэл	-92,636,349.9	-93,763,194.9
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	65,733,860.0	66,968,960.0
39208	Хуримтлагдсан элэгдэл	-26,285,582.4	-35,241,517.3
39209	Зам, гүүрний байгууламж	198,667,540.0	198,667,540.0
39210	Хуримтлагдсан элэгдэл	-118,573,298.7	-125,093,996.4
39214	Бусад үндсэн хөрөнгө	670,595,516.0	706,618,196.0
39215	Хуримтлагдсан элэгдэл	-67,750,184.5	-126,723,300.1
393	Биет бус хөрөнгө	43,850,854.1	140,767,397.5
39301	Программ хангамж	2,780,000.0	2,780,000.0
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2,292,500.0	-2,367,500.0
39303	Бусад биет бус хөрөнгө	46,804,282.5	149,224,282.5
39304	Хуримтлагдсан элэгдэл	-3,440,928.5	-8,869,385.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,325,901,369.5	3,283,833,883.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	935,262,210.0	71,239,300.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	935,262,210.0	71,239,300.0
413	Өглөг	935,262,210.0	71,239,300.0
4136	Бусад өглөг	935,262,210.0	71,239,300.0
41361	Байгууллагад төлөх өглөг	935,262,210.0	71,239,300.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,390,639,159.5	3,212,594,583.4
51	Засгийн газрын хувь оролцоо	2,390,639,159.5	3,212,594,583.4
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	575,302,155.7	575,302,155.7
51101	Өмч: - төрийн	575,302,155.7	575,302,155.7
512	Хуримтлагдсан үр дүн	1,504,326,415.8	2,326,281,839.7
51210	Өмнөх үеийн үр дүн	1,504,326,415.8	1,954,349,325.8
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	371,932,513.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	311,010,588.0	311,010,588.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,325,901,369.5	3,283,833,883.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,049,925,575.1	1,617,937,238.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	547,048,029.6	133,793,220.0
120	Нийтлэг татварын бус орлого	547,048,029.6	133,793,220.0
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	531,097,555.0	133,793,220.0
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	531,097,555.0	133,793,220.0
120009	Бусад орлого	15,950,474.6	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,877,545.5	1,484,144,018.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,135,118.0	554,639,005.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан тө	97,135,118.0	554,639,005.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,405,742,427.5	929,505,013.6
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн тө	1,405,742,427.5	929,505,013.6
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	840,213,045.1	1,246,004,724.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	767,099,345.1	1,246,004,724.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	752,575,145.8	1,100,316,552.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,797,859.4	496,885,089.8
210101	Үндсэн цалин	274,794,182.6	266,294,139.8
210102	Нэмэгдэл	67,003,676.8	215,846,152.4
210104	Урамшуулал	0.0	14,744,797.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,413,684.0	70,561,167.0
210201	Тэтгэврийн даатгал	32,241,282.0	49,453,809.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,793,074.0	5,276,803.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,034,364.0	2,638,481.0
210204	Ажилгүйдлийн даатгал	758,716.0	2,638,481.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,586,248.0	10,553,593.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,469,849.9	85,943,878.3
210301	Гэрэл, цахилгаан	13,456,928.2	15,388,600.1
210302	Түлш, халаалт	31,812,921.7	68,555,278.2
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	2,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,277,600.0	36,435,560.0
210401	Бичиг хэрэг	2,039,100.0	3,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	19,677,600.0	27,735,560.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,560,900.0	2,700,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	3,000,000.0	3,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.0	10,000,000.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	10,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,634,000.0	7,718,000.0
210702	Дотоод албан томилолт	4,634,000.0	7,718,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	12,942,083.0	132,744,790.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилг	12,109,100.0	131,660,950.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	99,297.0	381,700.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,686.0	132,640.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.0	137,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	263,040,069.6	260,028,067.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	192,766,218.7	71,276,001.6
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	70,273,850.9	188,752,066.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,524,199.3	145,688,172.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.0	33,050,257.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	6,022,680.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.0	6,135,300.0
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан А	0.0	14,892,277.5

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	6,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,524,199.3	112,637,914.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,524,199.3	112,637,914.5
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	73,113,700.0	0.0
2200	Дотоод эх үүсвэрээр	73,113,700.0	0.0
220001	Барилга байгууламж	25,806,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	47,307,700.0	0.0
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	1,209,712,530.0	371,932,513.9
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	150,380,837.0	0.0
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	2,418,367.0	0.0
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	147,962,470.0	0.0
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-150,380,837.0	0.0
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1,059,331,693.0	371,932,513.9

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,518,828,020.1	1,484,144,018.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	15,950,474.6	0.0
120	Нийтлэг татварын бус орлого	15,950,474.6	0.0
120009	Бусад орлого	15,950,474.6	0.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,502,877,545.5	1,484,144,018.7
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	97,135,118.0	552,639,005.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан	97,135,118.0	552,639,005.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,405,742,427.5	929,505,013.6
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн	1,405,742,427.5	929,505,013.6
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	615,386,769.6	1,432,544,038.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,386,769.6	1,432,544,038.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	600,862,570.3	1,287,155,326.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	341,797,859.4	500,973,518.3
210101	Үндсэн цалин	274,794,182.6	271,410,471.3
210102	Нэмэгдэл	67,003,676.8	214,818,249.4
210104	Урамшуулал	0.0	14,744,797.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,413,684.0	70,561,167.0
210201	Тэтгэврийн даатгал	32,241,282.0	49,453,809.0
210202	Тэтгэмжийн даатгал	3,793,074.0	5,276,803.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,034,364.0	2,638,481.0
210204	Ажилгүйдлийн даатгал	758,716.0	2,638,481.0
210205	Эрүүл мэндийн даатгал	7,586,248.0	10,553,593.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,469,849.9	85,943,878.3
210301	Гэрэл, цахилгаан	13,456,928.2	15,388,600.1
210302	Түлш, халаалт	31,812,921.7	68,555,278.2
210303	Цэвэр, бохир ус	200,000.0	2,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	27,277,800.0	35,850,810.0
210401	Бичиг хэрэг	2,039,100.0	3,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	19,677,800.0	27,735,310.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,560,900.0	2,700,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	3,000,000.0	2,415,500.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,000,000.0	4,170,000.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	4,170,000.0
2107	Томилолт, зочны зардал	4,634,000.0	7,718,000.0
210702	Дотоод албан томилолт	4,634,000.0	7,718,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	12,952,983.0	183,848,953.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйл	12,120,000.0	182,765,113.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	99,297.0	226,810.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	246,686.0	269,530.0

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.0	155,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,316,394.0	398,089,000.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	111,316,394.0	398,089,000.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	14,524,199.3	145,388,712.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.0	32,750,797.5
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	0.0	5,723,220.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн т	0.0	6,135,300.0
213208	ХОНТС-тай ажилласан албан хаагчдад төрөө	0.0	14,892,277.5
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	6,000,000.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,524,199.3	112,637,914.5
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,524,199.3	112,637,914.5
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(903,441,250.5	49,599,980.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	903,441,250.5	49,599,980.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	903,441,250.5	49,599,980.0
2200	Дотоод эх үүсвэрээр	903,441,250.5	49,599,980.0
220001	Барилга байгууламж	685,815,869.5	0.0
222001	Тоног төхөөрөмж	7,940,000.0	0.0
223001	Бусад хөрөнгө	54,463,700.0	0.0
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	155,221,681.0	49,599,980.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР	-903,441,250.5	-49,599,980.0
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	0.0
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	0.0

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2022 оны 12-р сарын 31-нээрх	575,302,155.7	311,010,588.0	(137,733,929.0)	748,578,814.7
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.7	311,010,588.0	(137,733,929.0)	748,578,814.7
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(14,738,187.0)	(14,738,187.0)
C08	2023 оны 12-р сарын 31-нээрх	575,302,155.7	311,010,588.0	1,504,326,415.8	2,390,639,159.5
D01	2023 оны 12-р сарын 31-нээрх	575,302,155.7	311,010,588.0	1,504,326,415.8	2,390,639,159.5
D02	Нягтлан бодох бүртгэлийн бод	-	-	450,022,910.0	450,022,910.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	575,302,155.7	311,010,588.0	1,954,349,325.8	2,840,662,069.5
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	371,932,513.92	371,932,513.92
D09	2024 оны 12-р сарын 31-нээрх	575,302,155.7	311,010,588.0	2,326,281,839.72	3,212,594,583.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	966,419,000.0	929,505,013.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	966,419,000.0	929,505,013.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	947,675,700.0	910,761,713.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	472,788,900.0	450,684,395.3
210101	Үндсэн цалин	280,976,600.0	233,375,413.1
210102	Нэмэгдэл	176,920,100.0	202,564,184.6
210104	Урамшуулал	14,892,200.0	14,744,797.6
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	64,274,900.0	64,274,900.0
210201	Тэтгэврийн даатгал	45,179,200.0	45,179,200.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,773,900.0	4,773,900.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,387,000.0	2,387,000.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,387,000.0	2,387,000.0
210205	Эрүүл мэндийн даатгал	9,547,800.0	9,547,800.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	100,497,200.0	85,943,878.3

210301	Гэрэл, цахилгаан	22,997,900.0	15,388,600.1
210302	Түлш, халаалт	75,499,300.0	68,555,278.2
210303	Цэвэр, бохир ус	2,000,000.0	2,000,000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	31,205,300.0	31,205,300.0
210401	Бичиг хэрэг	3,000,000.0	3,000,000.0
210402	Тээвэр, шатахуун	22,505,300.0	22,505,300.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,700,000.0	2,700,000.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	3,000,000.0	3,000,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,420,000.0	12,420,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,420,000.0	2,420,000.0
210604	Урсгал засвар	10,000,000.0	10,000,000.0
2107	Томилолт, зочны зардал	7,038,000.0	7,038,000.0
210702	Дотоод албан томилолт	7,038,000.0	7,038,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	200,590,000.0	200,333,840.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ	199,250,000.0	199,250,000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	432,000.0	432,000.0
210803	Даатгалын үйлчилгээ	450,000.0	226,810.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	300,000.0	269,530.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	158,000.0	155,500.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	58,861,400.0	58,861,400.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,861,400.0	58,861,400.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,743,300.0	18,743,300.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,743,300.0	18,743,300.0
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	6,608,000.0	6,608,000.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	6,135,300.0	6,135,300.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,000,000.0	6,000,000.0
0	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	966,419,000.0	931,505,013.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	966,419,000.0	929,505,013.6
132001	Орон нутгийн төсвөөс	966,419,000.0	929,505,013.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	22.0	22.0
620001	Удирдах ажилтан	3.0	3.0
620002	Гүйцэтгэх ажилтан	4.0	4.0
620003	Үйлчлэх ажилтан	15.0	15.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	113,085,592.58	552,639,005.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	113,085,592.58	552,639,005.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,031,429.17	425,108,813.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	14,352,451.17	50,289,123.00
210102	Нэмэгдэл	14,352,451.17	50,289,123.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,282,184.00	6,286,267.00
210201	Тэтгэврийн даатгал	1,551,882.00	4,274,609.00
210202	Тэтгэмжийн даатгал	182,574.00	502,903.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	146,064.00	251,481.00
210204	Ажилгүйдлийн даатгал	36,516.00	251,481.00
210205	Эрүүл мэндийн даатгал	365,148.00	1,005,793.00
2104	Хангамж, бараа материалын зардал		5,230,010.00
210402	Тээвэр, шатахуун		5,230,010.00
2107	Томилолт, зочны зардал		680,000.00
210702	Дотоод албан томилолт		680,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур		902,113.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээ		902,113.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	87,396,794.00	361,721,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	87,396,794.00	361,721,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,054,163.41	127,530,192.04

2132	Бусад урсгал шилжүүлэг		14892277.5
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан		14892277.5
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	9,054,163.41	112,637,914.54
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олг	9,054,163.41	112,637,914.54
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	113,085,592.58	552,639,005.04
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	113,085,592.58	552,639,005.04
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт шатны хува	96,182,452.00	552,639,005.04
131105	Төсвийн байгууллагын хүрээнд бий болсон нэмэлт о	16,903,140.58	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар 142,407.4 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан болно.

Залруулсан алдаа:

- Санхүүгийн байдлын тайланд ЗДТГ-ын шинэ барилгын ажлын гүйцэтгэлд төлөх өр төлбөрийн үлдэгдлийг 71,168.1 мянган төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн байна.
- Е-тайланд 71,239.3 мянган төгрөгийн өр төлбөрийг тооцоо нийлсэн актгүй гэж тодруулга тайланд тайлагнасан байна.
- ЗДТГ-ын 11 газар эзэмших эрхийн 102,420.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.
- Үндсэн хөрөнгөнд дансанд бүртгэлтэй 27 нэрийн 312.462.9 мянган төгрөгийн хөрөнгийн ашиглах жилийг алдаатай бүртгэж санхүүгийн программд оруулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

Залруулагдаагүй нийт 1,498.2 мянган төгрөгийн зөрчлөөс 1,498.2 мянган төгрөгийн материаллаг зөрчил нь урьдчилан тогтоосон материаллаг байдлын түвшнээс 7,742.4 мянган төгрөгөөр бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 1,498.2 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,498.2 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх 1 зөвлөмж хүргүүлээ.

Залруулаагүй алдаа:

Төлбөрийн акт

1. Төрийн захиргааны албан хаагчдад хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны мөнгөн урамшуулал 14,982.2 мянган төгрөгөөс 1,498.2 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон зөрчил илэрлээ. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1-д “ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого”, 22 дугаар зүйлийн 22.1.1-д “хууль тогтоомжид тусгайлан заасны дагуу олгож байгаа тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үзүүлж байгаа хөнгөлөлт, нөхөн олговор болон нэг удаагийн буцалтгүй тусламж”, Төсвийн тухай

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.8-д “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэж заасныг үндэслэн төлбөрийн акт тогтоов.

Албан шаардлага

1. Өмнөх онд 21.479.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн актаас 13,737.1 мянган төгрөгийг төсөвт төлж барагдуулан үлдэгдэл 7,742.4 мянган төгрөгийг төлүүлээгүй байна. Энэ Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д “Хариуцлагатай байх”, энэ хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ” гэж заасныг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.2-д “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд “Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн албан шаардлага тогтоов.

Зөвлөмж

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт:

Төсвийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-д “аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах” гэснийг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, батлуулах, мөн хэрэгжүүлэх талаар сургалт зохион байгуулж, ажилтнуудад мэдлэг, ур чадвар олгон өмнөх зөрчлийг давтан гаргахгүй байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой		Үүнээс Залруулсан	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Санхүүгийн байдлын тайланд ЗДТГ-ын шинэ барилгын ажлын гүйцэтгэлд төлөх өр төлбөрийн үлдэгдлийг зөрүүтэй бүртгэсэн байна.	1	71,168.1	1	71,168.1			1	71,168.1
2	Е-тайланд өр төлбөрийг тооцоо нийлсэн актгүй гэж тодруулга тайланд тайлагнасан байна.	1	71,239.3			1	71,239.3	1	71,239.3
3	ЗДТГ-ын 11 газар эзэмших эрхийг биет бус хөрөнгөөр санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	102,420.0	1	102,420.0			1	102,420.0
4	Үндсэн хөрөнгөнд дансанд бүртгэлтэй 27 нэрийн хөрөнгийн ашиглах жилийг алдаатай бүртгэсэн.	1	312,462.9			1	312,462.9	1	312,462.9
Нийт дүн		4	557,290.3	2	173,588.1	2	383,702.2	4	557,290.3

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил				Үүнээс			
		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж			
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
1	Төсвийн байгууллагад мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж баталж мөрдөөгүй байна.	1	-					1	-
2	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгосон мөнгөн урамшууллаас ХХОАТ-ыг суутган тооцож аваагүй олгосон байна.	1	1,498.2	1	1,498.2				
3	Өмнөх онд 21.479.5 мянган төгрөгийн 3 төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй байна.	1	7,742.4			1	7,742.4		
Нийт дүн		3	9,240.6	1	1,498.2	1	7,742.4	1	-

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn